



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"АРИГГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Бид "АРИГГАЛ" ХК-ийн (цаашид "компани" гэх) 2014 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах хорооноос баталсан, заавар журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт, ёс зүйн шаардлагын дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах түүврийн горимыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдлыг харгалзаж үздэг ба энэ талаар дүгнэлт гаргах зорилгоор биш, зөвхөн тухайн нөхцөлд зохистой аудитын горимуудыг тодорхойлоход чиглэдэг.

Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодит байдал, санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгыг үнэлэх ажлуудыг багтаана.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

(үргэлжлэл)

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.


Дүгнэлт

Бидний дүгнэлтээр “АРИГГАЛ” ХК-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар бэлтгэгдсэн эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн яамнаас баталсан, заавар журмын дагуу үнэн зөв, бодитой толилуулсан байна.

Онцлох зүйл

Нийт пассивын 73.1 хувийг өр төлбөр, 18.9 хувийг эздийн өмч тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна.

Компанийн нийт өрийн 96 хувь нь төлбөгдөх хугацаа болоогүй байгаа тул компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. Бид энэ талаар санхүүгийн тайланд хангалттай тодруулга хийсэн гэж тооцож байгаа ба үүнтэй уялдуулан аудитын дүгнэлтээ хязгаарлаагүй болно.



ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2015 ОНЫ 4 ДҮГЭЭР
САРЫН 28-НЫ ӨДӨР

“АРИГГАЛ” ХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Тодруулга	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31
Хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	5.1	145,792,805.27	166,366,259.28
Дансны авлага	5.2	35,783,879,230.17	42,549,167,714.80
Татварын авлага	5.3	3,739,096.62	-
Бараа материал	5.4	125,725,972.90	35,726,374.60
Бусад эргэлтийн хөрөнгө	5.5	229,595.05	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		<u>36,059,366,700.01</u>	<u>42,751,260,348.68</u>
Үндсэн хөрөнгө	5.6	3,345,678,312.14	3,226,919,483.23
Биет бус хөрөнгө	5.7	31,079,468.48	29,443,706.96
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5.8	18,186,257,829.68	18,186,257,829.68
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	5.7	73,871,155.85	73,871,155.85
Хойшлогдсон татварын хөрөнгө	5.9	3,102,822,659.42	5,698,293,665.96
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<u>24,739,709,425.57</u>	<u>27,214,785,841.68</u>
Нийт хөрөнгө		<u>60,799,076,125.58</u>	<u>69,966,046,184.42</u>
Өр төлбөр ба эзэмшигчийн өмч			
Дансны өглөг		41,796,068,555.22	51,163,071,076.10
Цалингийн өглөг		9,978,878.00	13,674,411.00
Татварын өр		161,572,201.79	73,319,290.82
НДШ-ийн өглөг		144,670.75	1,380,940.40
Богино хугацаат зээл	5.10	4,995,000,000.00	4,160,000,000.00
Ногдол ашгийн өглөг		55,673,150.00	275,207,250.00
Урьдчилж орсон орлого		1,426,965.82	3,168,265.16
Бусад богино хугацаат өр төлбөр		1,074,561,865.7	1,067,403,606.67
Нийт өр төлбөр		<u>48,094,426,287.28</u>	<u>56,757,224,840.15</u>
Эздийн өмч			
Хувийн өмч		347,932,000.00	347,932,000.00
Халаасны хувьцаа		(52,490,400.00)	(52,490,400.00)
Нэмж төлөгдсөн капитал		208,198.40	208,198.40
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5.11	6,683,611,872.05	6,683,611,872.05
Хуримтлагдсан ашиг		5,725,388,167.85	6,229,559,673.82
Эздийн өмчийн дүн		<u>12,704,649,838.30</u>	<u>13,208,821,344.27</u>
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		<u>60,799,076,125.58</u>	<u>69,966,046,184.42</u>

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

“АРИГГАЛ” ХК
АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Тодруулга	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31
Борлуулалтын орлого	5.12	3,960,181.82	69,656,245.50
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5.13	248,505.38	64,123,229.87
Нийт ашиг (алдагдал)		<u>3,711,676.44</u>	<u>5,533,015.63</u>
Түрээсийн орлого		92,451,266.11	118,993,136.27
Хүүгийн орлого	5.12	918,844,138.74	170,021,598.25
Ногдол ашгийн орлого		300,000,000.00	1,458,149,940.00
Бусад орлого		-	171,874.55
Ерөнхий удирдлагын зардал	5.14	(400,601,947.08)	(807,931,534.61)
Бусад зардал	5.14	(169,935,771.49)	(1,067,080,563.85)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, (гарз)	5.12	8,256,633.57	862,850,299.56
Татвар төлөхийн өмнөх ашиг		<u>752,725,996.29</u>	<u>740,707,775.25</u>
Орлогын татварын зардал	5.15	91,884,413.87	17,002,159.83
Татварын дараах ашиг, (алдагдал)		<u>660,841,582.42</u>	<u>723,705,615.42</u>
Цэвэр ашиг		<u>660,841,582.42</u>	<u>723,705,615.42</u>
Нийт энгийн хувьцаа		3479320	3479320
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг, (алдагдал)		189.93	208.00

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

"АРИГГАЛ" ХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи

Үзүүлэлтүүд	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	(тогтоогоор)
						Нийт дүн
12 оны 12 сарын 31-ний дэгдэл	347,932,000.00	(52,490,400.00)	208,198.40	6,683,611,872.05	5,033,369,108.12	12,012,630,778.57
ЗБ-ийн алдааны залруулга	-	-	-	-	31,177,477.31	31,177,477.31
йлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	660,841,582.42	660,841,582.42
13 оны 12 сарын 31-ний дэгдэл	<u>347,932,000.00</u>	<u>(52,490,400.00)</u>	<u>208,198.40</u>	<u>6,683,611,872.05</u>	<u>5,725,388,167.85</u>	<u>12,704,649,838.30</u>
йлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	723,705,615.42	723,705,615.42
рласан ногдол ашиг	-	-	-	-	(219,534,100.00)	(219,534,100.00)
14 оны 12-р сарын 31-ий үлдэгдэл	<u>347,932,000.00</u>	<u>(52,490,400.00)</u>	<u>208,198.40</u>	<u>6,683,611,872.05</u>	<u>6,229,559,673.82</u>	<u>13,208,821,344.27</u>

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

MONGOL KPMG AUDIT Co., Ltd
CPAs & REGISTERED AUDITORS

"АРИГГАЛ" ХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2014 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болсон жилийн хувьд

Үзүүлэлтүүд	(төгрөгөөр)	
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн +/-	<u>9,154,510,811.31</u>	<u>4,424,209,652.86</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	123,966,637.30	132,399,606.17
Бусад мөнгөн орлого	9,030,544,174.01	4,291,810,046.69
Мөнгөн зарлагын дүн -/	<u>(8,266,504,700.40)</u>	<u>(2,721,021,248.85)</u>
Ажиллагсадад олгосон мөнгө	81,233,670.00	153,256,467.70
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	114,953,928.26	38,900,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	5,883,010.00	3,616,450.00
Ашиглалтын зардалд төлсөн	9,347,066.00	7,852,885.98
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	431,500.00	1,773,800.00
Хүүний төлбөрт	1,415,792,391.82	969,735,954.82
Татварын байгууллагад төлсөн	161,530,600.35	271,594,722
Бусад мөнгөн зарлага	6,477,332,533.97	1,274,290,968.35
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>888,006,110.91</u>	<u>1,703,188,404.01</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн +/-	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Мөнгөн зарлагын дүн -/	<u>(877,073,173.63)</u>	<u>(1,682,614,950.00)</u>
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн	858,345,400.00	1,682,614,950.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Төлсөн ноцдол ашиг	18,727,773.63	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>(877,073,173.63)</u>	<u>(1,682,614,950.00)</u>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>10,932,937.28</u>	<u>20,573,454.01</u>
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>134,859,867.99</u>	<u>145,792,805.27</u>
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>145,792,805.27</u>	<u>166,366,259.28</u>

Хавсаргасан тайлбар тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

"АРИГГАЛ" ХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
 /2014 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар/

1. КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Байршил:	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 4-р хороо, Улаанбаатар-6, "Ариггал" ХК-ийн байр Утас: +976-11-342814 Факс: +976-11-343033
Өмчийн хэлбэр	Хувьцаат компани
Байгуулагдсан огноо:	Эрмэл ХК нь 1981 онд хуучин нэрээр ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар цэвэр болон хагас ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүлжмэл болон нэхмэлийн үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах үүрэгтэйгээр байгуулагдаж байсан байна. Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 81 тоот тогтоолоор бүрэн хувьчлагдаж, хувьцаат компани болон зохион байгуулагдсан.
Хувьцаа эзэмшигч:	Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
Хувьцааны тоо	Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 3479320 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
Охин компаниуд	"Ариггал" ХК-нь "Компанийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 13-д заасны дагуу "Ариггал" ХК нэгдэлд хамаардаг бөгөөд нийт 3 охин компани, охин компаниуд нь дороо 6 охин компанитай.
Тусгай зөвшөөрөл:	Кадастрын хэлтсийн даргын 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 309 дугаар шийдвэрээр Ашигт малтмалын хайгуулын XV-013990 тоот тусгай зөвшөөрлийг хугацааг 2017 оны 8 дугаар сарын 12-ны өдрийг дуустал 3 жилийн хугацаагаар сунгуулсан.
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	<ol style="list-style-type: none"> 1. Инженерийн байгууламжийн үйлчилгээ үзүүлэх 2. Техник тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, будаг химийн материал импортоор нийлүүлэх, худалдах; 3. Өөрөө болон өөр байгууллагатай хамтран худалдаа үйлчилгээ явуулах, нэрийн барааны дэлгүүр, үйлчилгээний салбар нэгж ажиллуулах; 4. Дотоод, гадаад байгууллага, компаниудтай хорших, техник технологи, мэдээлэл, мэргэжилтэн, ажилчид солилцох, хамтран ажиллах, хамтарсан үйлдвэрлэл зохион байгуулах, бусдад зуулчлах зэрэг хамтын ажиллагааны ашигтай бүх хэлбэрийг сонгон хэрэглэх; 5. Үйлдвэрийн болон иргэний барилга байгууламж, засвар үйлчилгээ хийх, шинэчлэх, шинээр барих, түрээслэх, барилгын материалын худалдаа хийх; 6. Өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан шаардлагатай бол компанийн хөрөнгөөр барьцаа, баталгаа гаргаж болно.
Тайланг хамарсан хугацаа:	2014 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ийг дуустал
Тайланг хугацаанд гарсан онцлог үйл явдал:	"Эрмэл" ХК / хуучин нэрээр/ нь 2014 оноос "Ариггал" ХК болж нэрээ өөрчлөн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

- а) **Хөрөнгө** гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд болон бий болгохоор хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн үр өгөөж байдлаар компанийн эзэмшилд байгаа нөөц юм.

Хөрөнгө нь аж ахуйн нэгжид эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг авчрах магадлалтай бөгөөд түүний өртөг эсвэл үнийг найдвартай хэмжих боломжтой бол балансад тусгахаар хүлээн зөвшөөрдөг.

Хөрөнгө нь тайлангийн хугацаанд эдийн засгийн үр өгөөжгүйгээр зардал гаргаж байгаа үед балансад тусгахыг хүлээн зөвшөөрөхгүй. Харин ийм ажил гүйлгээний үр дүнд орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

- б) **Өр төлбөр** гэдэг нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн үр өгөөжийг өөртөө агуулж байгаа нөөцөөс гарах үр дүн хүлээгдэж буй төлбөр тооцоо болон өнгөрсөн үйл явдлаас үүссэн өнөөгийн хүлээх үүрэг юм.

Одоо байгаа өр төлбөрийг барагдуулснаар эдийн засгийн үр өгөөжийг агуулж байгаа нөөц хасагдах магадлалтай, мөн төлбөрийг барагдуулах дүнг найдвартай хэмжих боломжтой үед өр төлбөрийг балансанд хүлээн зөвшөөрнө.

- с) **Өмч** гэдэг нь аж ахуйн нэгжийн хөрөнгөөс бүх өр төлбөрийг хассаны дараа үлдэх хувь оролцоо юм.
- д) **Орлого** гэж хөрөнгийг бий болгох буюу нэмэгдүүлэх хэлбэрээр тайлангийн хугацаанд эдийн засгийн үр өгөөжийн өсөлт буюу өмч эзэмшигчдийн оруулснаас бусад хэлбэрээр өмчийг нэмэгдүүлэхэд хүргэсэн өр төлбөрийн бууралтыг хэлнэ.

Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн найдвартай хэмжих боломжтой өсөлт нь хөрөнгийг нэмэгдүүлж эсвэл өр төлбөрийг багасгаж байвал орлогын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө.

Зардал гэж хөрөнгийг хасагдуулж, элэгдүүлэх хэлбэрээр тайлангийн хугацаанд гарсан эдийн засгийн үр өгөөжийн бууралт буюу өмч эзэмшигчдэд хуваарилахаас бусад байдлаар өмчийг бууруулахад хүргэсэн өр төлбөрийн өсөлтийг хэлнэ. Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн найдвартай хэмжих боломжтой бууралт нь хөрөнгийг багасгах эсвэл өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

Гарсан зардал болон олсон орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

Эдийн засгийн үр өгөөж нь хэд хэдэн тайлангийн үед гарахаар хүлээгдэж байгаа ба орлоготой шууд болон шууд бусаар холбогдон тодорхойлогдох зардлыг оновчтой хуваарилалтын аргыг үндэслэж орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Зардал нь эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг бий болгохгүй буюу эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн шалгуур хангагдахгүй байгаа эсвэл хөрөнгийг балансанд хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдахаа болисон үед зардлыг нэн даруй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУСГАЙ БОДЛОГУУД

4.1 Мөнгө ба түүнтэй адилтгах орлого

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө болон банкин дахь харилцах дансдуудаас бүрдэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаар гарсан мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

4.2 Гадаад валютаарх ажил гүйлгээг тайлагнах

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг

Тайлант үе бүрийн эцэст:

- a) гадаад валютаар илэрхийлсэн мөнгөн зүйлсийг Монгол банкны хаалтын ханшаар тайлагнана
- b) гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны ханшаар тайлагнана.
- c) гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг уг бодит үнэ цэнийг тодорхойлж байсан өдрийн Монгол банкны ханшаар тайлагнана.

Мөнгөн зүйлсийн төлбөр тооцоо болон мөнгөн зүйлсийг тайлант үе эсвэл өмнөх санхүүгийн тайланд анх хүлээн зөвшөөрөхдөө хөрвүүлж байсан ханшнаас өөр ялгаатай ханшаар хөрвүүлсэнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн үеийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Мөнгөн зүйлс нь гадаад валютаарх ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд уг ажил гүйлгээ гарсан өдөр ба барагдуулалтын өдрийн ханш өөрчлөгдсөн үед ханшийн зөрүү үүсдэг.

Ажил гүйлгээ гарсан болон төлбөр барагдуулсан хугацаа нь нягтлан бодох бүртгэлийн нэг ижил үед хамаарч байвал ханшийн бүх зөрүүг тухайн тайлант үед хийвэл төлбөр хийх хүртэлх тайлант үе бүрт хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүг тайлант үе бүрийн валютын ханшийн өөрчлөлтөөр тодорхойлно.

Мөнгөн бус зүйлсийн олз, гарзыг компани бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн бол тухайн хөрвүүлэлтээс үүссэн олз, гарзыг мөн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

4.3 Бараа материал

Бараа материалд дараах хөрөнгө орно.

1. Компанийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа хөрөнгө
2. Дээрх борлуулалтын зорилгоор үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс
3. Үйлдвэрлэлийн дамжлага эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлнэ.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчирхтай холбогдож гарсан бүх зардал орно.

4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг ба үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг болон хөрөнгийн ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрддэг.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлын өртгийг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед зардлыг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Урсгал засварын зардал гэх мэт бусад зардлуудыг хүлээн зөвшөөрдөг.

Компани үндсэн хөрөнгөндөө Монгол улсын “ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-д заасан ашиглалтын хугацааг баримтлан шулуун шугамын аргаар элэгдэл тооцсон.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийг ашиглах боломжтой болсон үеэс эхэлж байгуулдаг. Хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах эсвэл хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн үр өгөөжгүй болсон үед нь данснаас хасдаг. Үндсэн хөрөнгийн данснаас хассаны олз эсвэл гарзыг (үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассаны цэвэр орлогын зөрүүгээр тооцсон) тухайн жилийн дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

4.5 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй тодорхойлогдох боломжтой мөнгөн бус хөрөнгө юм. Үүнд: Лиценз, программ хангамж, хайгуул болон үнэлгээний хөрөнгө, бусад биет бус хөрөнгийг бүртгэсэн.

Биет бус хөрөнгийг худалдан авсан анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан хрогдуулга болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Биет бус хөрөнгөндөө Монгол улсын “ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-д заасан ашиглалтын хугацааг баримтлан шулуун шугамын аргаар элэгдэл тооцсон.

Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хүлээгдэж буй эдийн засгийн ашиглагдах жилийн туршид шулуун шугамын аргаар хорогдуулдаг ба тусгай зөвшөөрлийн үнэ цэнэ буурч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг үнэлдэг.

Хайгуул болон үнэлгээний өртгийг ирээдүйд нөхөн олж авах боломжтой аль эсвэл үйл ажиллагаа нь нөөцийн зохистой үнэлгээг хийх үе шатандаа очоогүй байгаа үед өртгийг капиталжуулдаг.

Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг анх хэмжихдээ дараахь зардлуудыг оруулж болно. (Зөвхөн энэ жагсаалтаар хязгаарлагдахгүй);

- a) Хайгуул хийх эрхийг олж эзэмших
- b) Газар зүйн байршил, геологи, геохими болон геофизикийн судалгаа шинжилгээ хийх

- с) Хайгуулын өрөмдлөг хийх
- д) Малгалт хийх
- е) Дээж авах
- ф) Ашигт малмталын хайгуулын явцад техник эдийн засгийн үндэслэл ба арилжааны үр ашгийн боломжийг үнэлэхдээ холбоотой үйл ажиллагаа гм.

Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг өртгөөр нь хэмжинэ.

Бусад биет бус хөрөнгийг хүлээгдэж буй ашиглагдах жилийн туршид шулуун шугамын аргаар хорогдуулдаг ба тусгай зөвшөөрлийн үнэ цэнэ буурч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг үнэлдэг. Хорогдуулгын зардлыг орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

4.6 Санхүүгийн өр төлбөр ба эздийн өмч

Санхүүгийн өр төлбөр нь компанийн гаргасан өрийн бичиг, вексел, бонд зэргээс бүрддэг.

Санхүүгийн өр төлбөрийг компани уг хэрэгсэлтэй холбоотой гэрээний нэг тал болсон үед санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн өр төлбөрийг анхлан бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Санхүүгийн өр төлбөрийг худалдан гаргахтай холбоотой шууд зардал болон шимтгэлийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн дээр нэмж, эсвэл түүнээс хасч бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөрийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх болон хорогдуулсан өртгөөр илэрхийлэх гэж хоёр ангилдаг.

Бодит үнэ цэн гэдэг нь ажил гүйлгээ бүртгэх өдөр зах зээлийн оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдахад төлөх үнэ эсвэл өр төлбөрөөр тооцох дүнг хэлнэ.

Санхүүгийн хэрэглүүрийн хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Үр ашигт хүүгийн арга нь санхүүгийн хөрөнгийн хорогдуулалтыг тооцоолон, хүүгийн орлогыг холбогдох хугацаанд нь хуваарилдаг арга юм. Компанийн гаргасан санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслүүд нь гэрээт ажлын мөн чанар болон санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу ангилагддаг.

Эздийн өмч нь компанийн хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хувь оролцоог хэлнэ.

Компанийн гаргасан өмчийн хэрэглүүрийг шууд гаргалтын зардлыг хассаны дараа хүлээн авах орлогоор нь бүртгэдэг.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн байвал өсөлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад хэсэгт дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлангийн өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Гэхдээ тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг өмнө нь ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөсөн бол тэр хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг мөн адил ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан байвал уг бууралтыг ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Гэхдээ дахин үнэлгээний бууралтыг өмнөх дахин үнэлгээний нэмэгдлийн кредит дүнгийн хэмжээгээр бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч болно.

Үндсэн хөрөнгийг данснаас хасах үед дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлагдсан тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

4.7 Түрээс

Түрээсийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэл, өгөөжийг түрээслэгчид шилжүүлж буй түрээсийг санхүүгийн түрээс гэнэ. Санхүүгийн түрээсийн шалгуурыг хангахгүй байгаа бүх төрлийн түрээсийг үйл ажиллагааны түрээс гэнэ.

Санхүүгийн түрээсийн үед түрээслүүлэгч нь хөрөнгөө данснаас хасч бүртгэх ба харин түрээслүүлэгч нь хөрөнгийг үнэлж, бүртгэнэ. Урт хугацаат түрээсийн гэрээний хувьд түрээсийн өглөг, авлагын үнэлгээг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж, хорогдуулна.

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг орлогын дэлгэрэнгүй тайланд орлого эсвэл зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

4.8 Болзошгүй өр төлбөр

Болзошгүй өр төлбөр нь компанийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд гарах боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь компанийн бүрэн хяналтад ороогүй, зөвхөн ирээдүйн нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдолд, эс тохиолдлоор батлагдах одоогийн үүрэг хариуцлага юм.

Болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөггүй боловч түүнийг тодруулдаг.

Компани гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрийн үлдэгдэлд валютын ханшны тэгшитгэл тооцоход үүсэх гарз нь компанийн эдийн засагт мэдэгдэхүйц хүндрэлтэй болох магадлал байна.

Компани 7 банкинд харилцах данстай боловч тайлант хугацааны эцсээр касст нийт мөнгөн хөрөнгийн 96.2 хувь нь байрших касст мөнгөн хөрөнгийн төвлөрөл их, эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Балансын нийт активын 60.8 хувийг авлага, 0.2 хувийг мөнгөн хөрөнгө, 0.05 хувийг бараа материал, 4.7 хувийг биет болон биет бус хөрөнгө, 25.9 хувийг хөрөнгө оруулалт, 0.1 хувийг хайгуул үнэлгээний хөрөнгө, 8.1 хувийг хөрөнгө оруулалтын зардал, нийт пассивын 73.1 хувийг өр төлбөр, 18.9 хувийг эздийн өмч тус тус эзэлж байгаа нь компанийн тасралтгүй үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл өндөр байгааг харуулж байна.

4.9 Тайлангийн дараах үйл явдал

Тайлангийн дараах үйл явдлууд нь компанийн тайлант хугацааны эцсийн санхүүгийн байдлын тухай нэмэлт мэдээллийг санхүүгийн тайланд тусгадаг.

Санхүүгийн тайлангийн тодруулагад толилуулсан тайлангийн дараах үйл явдлууд залруулагдахгүй.

4.10 Компанийн орлогын албан татвар

Компани санхүүгийн жилийн татвар ноогдуулах орлого, түүнд ноогдуулсан орлогын албан татварыг Монгол улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тодорхойлж, тайлагнадаг.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ноогдуулах жилийн орлогод 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж орлогын албан татвар ноогдуулж төлдөг. Компани тайлант хугацаанд татвар ноогдох орлого олоогүй тул 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар орлогын албан татвар ноогдуулж төлөөгүй болно.

4.11 Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүнийн орлогын албан татварыг ажиллагсдын цалин болон түүнтэй адилтгах орлого мөн гэрээт ажил гүйцэтгэгчийн хөлснөөс 10 хувиар тооцон ногдуулдаг. Ажил олгогч эсвэл үйлчилгээ хүлээн авагч нь ажиллагсдын цалин болон гэрээт ажил гүйцэтгэгчийн хөлснөөс хувь хүний орлогын албан татварыг суутгаж, ажиллагсад болон гэрээт ажилчдын өмнөөс татварын байгууллагад шилжүүлдэг.

4.12 Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын "Нийгмийн даатгалын тухай" хуулийн дагуу компани нь ажиллагсдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 10 хувиар, ажил олгогчоос 11 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

4.13 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол улсын "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ноогдох бараа, ажил үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож, НӨАТ төлдөг. Компанийн орлого 10 сая ба түүнээс дээш төгрөг хүрсэн тохиолдолд тухайн сарын дараагийн сараас эхлэн компани НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг.

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТУХАЙ

5.1 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Бэлэн мөнгө			
Касст байгаа бэлэн мөнгө төгрөг	109,340,858.00	159,516,919.97	50,176,061.97
Касст байгаа бэлэн мөнгө ам.доллар	9,087,625.40	394,683.96	(8,692,941.44)
Бэлэн мөнгөний үлдэгдэл	118,428,483.40	159,911,603.93	41,483,120.53
Банкин дахь харилцах			
ХААН банк төгрөг	21,091,980.04	242,525.43	(20,849,454.61)
ХААН банк ам.доллар	1,298,948.19	48,739.60	(1,250,208.59)
Голомт банкны мастер карт	343,064.00	343,064.00	-
Голомт банк төгрөг	20,162.33	20,162.33	-
Голомт банк ам.доллар	32,284.91	36,861.56	4,576.65
Чингис хаан банк төгрөг	20,001.56	20,001.56	-
Чингис хаан банк төгрөг	338,577.69	386,536.60	47,958.91
ХХБанк ам.доллар	63,666.31	72,684.51	9,018.20
Капитрон банк төгрөг	3,917,273.43	5,028,677.52	1,111,404.09
Капитрон банк валют	193,841.76	214,937.69	21,095.93
Хадгаламж банк төгрөг	9,445.69	9,445.69	-
Зоос банк 118 салбар төгрөг	10,258.18	7,258.18	(3,000.00)
Зоос банк 118 салбар валют фунт	21,824.16	23,711.36	1,887.20
Зоос банк 118 салбар ам.доллар	2,993.62	49.32	(2,944.30)
Банкин дахь харилцахын үлдэгдэл	27,364,321.87	6,454,655.35	(20,909,666.52)
Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийн дүн	145,792,805.27	166,366,259.28	20,573,454.01

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 20.5 сая төгрөг буюу 14.1 хувиар өссөн байна.

5.2 Авлага

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Дансны авлага			
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	251,409,573.33	298,505,731.29	47,096,157.96
Авлагын комисст шилжүүлсэн авлага	1,271,221,762.19	1,185,878,586.56	(85,343,175.63)
ГЭЗХэлтэст шилжүүлсэн авлага	2,084,199,407.90	2,370,499,596.51	286,300,188.61
СБХХэлтэст шилжүүлсэн авлага	32,058,881,270.57	38,568,797,825.26	6,509,916,554.69
Бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага	<u>35,665,712,013.99</u>	<u>42,423,681,739.62</u>	<u>6,757,969,725.63</u>
Худалдан авагчаас авах авлага	14,461,736.10	14,461,736.10	-
Гадаад худалдан авагчаас авах авлага	4,092,058.04	4,092,058.04	-
Авлагын комисст шилжүүлсэн авлага	86,170,471.54	85,396,471.54	(774,000.00)
Худалдан авагчдаас авах авлага	<u>104,724,265.68</u>	<u>103,950,265.68</u>	<u>(774,000.00)</u>
Ажиллагсад олгосон урьдчилгаа	13,442,950.50	20,647,180.50	7,204,230.00
Ажилчин албан хаагчдаас авах авлага	-	888,529.00	888,529.00
Ажиллагсдаас авах авлага	<u>13,442,950.50</u>	<u>21,535,709.50</u>	<u>8,092,759.00</u>
Дансны авлагын дүн	<u>35,783,879,230.17</u>	<u>42,549,167,714.80</u>	<u>6,765,288,484.63</u>

5.3 Татвар, ндш-ын авлага

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
ААНОАТ-ын авлага	3,739,096.62	-	(3,739,096.62)
Татвар, НДШ-ийн авлагын дүн	<u>3,739,096.62</u>	<u>=</u>	<u>(3,739,096.62)</u>

5.4 Бараа материал

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Бэлэн бүтээгдэхүүн	2,582,664.83	2,431,985.18	150,679.65
Сэлбэг хэрэгсэл	103,401,386.83	25,159,669.95	78,241,716.88
Хангамжийн материал	4,873,813.39	3,886,803.31	987,010.08
Сав, баглаа боодол	3,056,141.11	-	3,056,141.11
Бусад материал	11,811,966.74	4,247,916.16	7,564,050.58
Дүн	<u>125,725,972.90</u>	<u>35,726,374.60</u>	<u>89,999,598.30</u>

5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Эргэлтийн сүргийн мал амьтад	229,595.05	-	(229,595.05)
Бусад эргэлтийн хөрөнгийн дүн	<u>229,595.05</u>	=	<u>(229,595.05)</u>

5.6 Үндсэн хөрөнгө

(төгрөгөөр)

Анхны өртөг	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Барилга байгууламж	4,424,397,383.63	4,424,365,403.63	(31,980.00)
Машин тоног төхөөрөмж	7,185,840.42	7,141,965.86	(43,874.56)
Тээврийн хэрэгсэл	822,875.00	822,875.00	-
Тавилга, эд хогшил	53,890,334.06	53,600,591.62	(289,742.44)
Дүн	<u>4,486,296,433.11</u>	<u>4,485,930,836.11</u>	<u>(365,597.00)</u>

Хуримтлагдсан элэгдэл	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Барилга байгууламж	1,118,490,415.36	1,233,321,698.08	114,831,282.72
Машин тоног төхөөрөмж	4,550,796.27	4,676,468.07	125,671.80
Тээврийн хэрэгсэл	786,860.99	786,860.99	-
Тавилга, эд хогшил	16,790,048.35	20,226,325.74	3,436,277.39
Дүн	<u>1,140,618,120.97</u>	<u>1,259,011,352.88</u>	<u>118,393,231.91</u>

Үлдэгдэл өртөг	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Барилга байгууламж	3,305,906,968.27	3,191,043,705.55	(114,863,262.72)
Машин тоног төхөөрөмж	2,635,044.15	2,465,497.79	(169,546.36)
Тээврийн хэрэгсэл	36,014.01	36,014.01	-
Тавилга, эд хогшил	37,100,285.71	33,374,265.88	(3,726,019.83)
Дүн	<u>3,345,678,312.14</u>	<u>3,226,919,483.23</u>	<u>(118,758,828.91)</u>

5.7 Биет бус хөрөнгө

(төгрөгөөр)

Үлдэгдэл өртөг	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Газрын лицензийн эрх	32,715,230.00	29,443,706.96	(3,271,523.04)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	73,871,155.85	73,871,155.85	-
Дүн	<u>104,586,385.85</u>	<u>103,314,862.81</u>	<u>(3,271,523.04)</u>

Хуримтлагдсан элэгдэл	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Газрын лицензийн эрх	1,635,761.52	1,635,761.52	3,271,523.04
Дүн	<u>1,635,761.52</u>	<u>1,635,761.52</u>	<u>3,271,523.04</u>

Үлдэгдэл өртөг	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Газрын лицензийн эрх	31,079,468.48	29,443,706.96	(1,635,761.52)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	73,871,155.85	73,871,155.85	-
Дүн	<u>104,950,624.33</u>	<u>103,314,862.81</u>	<u>(1,635,761.52)</u>

5.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Кашмер холдинг ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт	18,065,346,659.64	18,065,346,659.64	-
Метро политан проперти ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00	-
Монгол ноолуур нэгдэлд оруулсан хөрөнгө оруулалт	8,000,000.00	8,000,000.00	-
Хувьцаат хөрөнгө оруулалт	111,911,170.04	111,911,170.04	-
Дүн	18,186,257,829.68	18,186,257,829.68	-

5.9 Хойшлогдсон татварын хөрөнгө

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Хүүгийн зардал	3,102,822,659.42	2,998,293,665.96	(104,528,993.46)
Ханшийн зөрүү	-	2,700,000,000.00	2,700,000,000.00
Дүн	<u>3,102,822,659.42</u>	<u>5,698,293,665.96</u>	<u>2,595,471,006.54</u>

5.10 Өр төлбөр

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Дансны өглөг	41,796,068,555.22	51,163,071,076.10	9,367,002,520.88
Цалингийн өглөг	9,978,878.00	13,674,411.00	3,695,533.00
Татварын өр	161,572,201.79	73,319,290.82	(88,252,910.97)
НДШ-ийн өглөг	144,670.75	1,380,940.40	1,236,269.65
Богино хугацаат өглөг	4,995,000,000.00	4,160,000,000.00	(835,000,000.00)
Ногдол ашгийн өглөг	55,673,150.00	275,207,250.00	219,534,100.00
Урьдчилж орсон орлого	1,426,965.82	3,168,265.16	1,741,299.34
Бусад богино хугацаат өглөг	1,074,561,865.70	1,067,403,606.67	(7,158,259.03)
Дүн	<u>48,094,426,287.28</u>	<u>56,757,224,840.15</u>	<u>8,662,798,552.87</u>

5.11 Эздийн өмч

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Хувьцаат капитал	347,932,000.00	347,932,000.00	-
Халаасны хувьцаа	(52,490,400.00)	(52,490,400.00)	-
Нэмж төлөгдсөн капитал	208,198.40	208,198.40	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	6,683,611,872.05	6,683,611,872.05	-
Хуримтлагдсан ашиг	5,725,388,167.85	6,229,559,683.27	504,171,515.42
Дүн	<u>12,704,649,838.30</u>	<u>13,208,821,353.72</u>	<u>=</u>

“ҮЦТТТХТ” ХХК-аас гаргасан судалгаагаар тус компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 3479320 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

ТУЗ-ийн 2014 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 14 тоот тогтоолоор 219,534,100.00 төгрөгийн ноогдол ашиг олгох шийдвэр гаргаж хуримтлагдсан ашиг данснаас ногдол ашгийн өглөг үүсгэсэн.

5.12 Орлого

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Бараа материал борлуулсны орлого	3,960,181.82	69,656,245.50	(65,696,063.68)
Түрээсийн орлого	92,451,266.11	118,993,136.27	(26,541,870.16)
Хүүний орлого	918,844,138.74	170,021,598.25	748,822,540.49
Ногдол ашгийн орлого	300,000,000.00	1,458,149,940.00	(1,158,149,940.00)
Бусад орлого	-	171,884.00	(171,884.00)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	8,256,633.57	862,850,299.56	(854,593,665.99)
Дүн	<u>1,323,512,220.24</u>	<u>2,679,843,103.58</u>	<u>(1,356,330,883.34)</u>

5.13 Борлуулсан барааны өртөг

(төгрөгөөр)

Ангилал	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Борлуулалтын өртөг	248,505.38	64,123,229.87	(63,874,724.49)
Дүн	<u>248,505.38</u>	<u>64,123,229.87</u>	<u>(63,874,724.49)</u>

5.14 Зардал

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Ерөнхий удирдлагын зардал:			
Цалин хөлс	105,121,819.80	160,302,445.73	-55,180,625.93
Нийгмийн даатгалын хөлс	12,477,569.80	22,464,392.36	-9,986,822.56
Албан томилолтын зардал	8,918,863.10	8,998,675.10	-79,812.00
Элэгдлийн зардал	119,882,369.02	119,840,143.56	42,225.46
Зар сурталчилгааны зардал	571,300.00		571,300.00
Шуудан холбооны зардал	6,385,639.46	5,842,269.30	543,370.16
Шатахууны зардал	2,976,680.40	3,603,800.00	-627,119.60
Бусад зардал-Банкны үйлчилгээний	447,901.68	79,006.95	368,894.73
Бичиг хэрэг	1,594,750.00	4,620,923.68	-3,026,173.68
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	60,484,221.82	403,152,150.78	-342,667,928.96
Бусад зардал	79,040,832.00	79,027,727.15	13,104.85
Сургалтын зардал	2,700,000.00	-	2,700,000.00
Дүн	<u>400,601,947.08</u>	<u>807,931,534.61</u>	<u>-407,329,587.53</u>
Бусад зардал:			
Бусад зардал	169,935,771.49	1,067,080,563.85	-897,144,792.36
Дүн	<u>169,935,771.49</u>	<u>1,067,080,563.85</u>	<u>(897,144,792.36)</u>

5.15 Орлогын албан татварын зардал

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2013 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31	Зөрүү
Орлогын татварын зардал	91,884,413.87	17,002,159.83	74,882,254.04
Дүн	<u>91,884,413.87</u>	<u>17,002,159.83</u>	<u>74,882,254.04</u>

Санхүүгийн тайлангийн тодруулагад нийт орлого зардлын үзүүлэлтүүдийн өсөлт бууралтыг зөрүү гэсэн баганаар харуулсан болно.

Аудиторын тайланг тайлбар тодруулгын хамт монгол хэл дээр 2 эх хувь бэлтгэсэн ба хуулбарт утгын зөрүү гарвал эх хувийг баримтлана.



2015 ОНЫ 4 ДҮГЭЭР
САРЫН 28-НЫ ӨДӨР